



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.20 № 01/544
танай _____-ны № _____-Т

ИРГЭНИЙ ХӨДӨЛГӨӨНИЙ НАМ
ХӨВСГӨЛ АЙМГИЙН НАМЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ГЭРЭЛТУЯА
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хорооны сонгуулийн мөрийн

хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Иргэний хөдөлгөөний намын хороонд

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**“НҮҮДЛИЙН СОЁЛТ ДЭЛХИЙН УЛС”
“НҮҮДЭЛЧДИЙН ИХ УЛС МОНГОЛ”**


“ҮНДЭСНИЙ СОЁЛТ НҮҮДЭЛЧИН МОНГОЛ АЙМАГ”

ЗОРИЛГО: “Нэгдмэл Эрх Зүйт Монгол Хөгжлийн төлөө” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. Дэлхийн Соёлын Ирээдүй Нүүдэлчин Монгол;
2. Экологийн цэвэр төгс хөгжилт Дэлхийн Монгол;
3. Дэлхийн Санхүү Эдийн Засгийн Сонгодог хөгжил Их Монгол улс

АРГА ЗАМ: “Нэгдмэл Эрх Зүйт Монгол Хөгжлийн төлөө” мөрийн хөтөлбөрийн хүрээнд

1. Нүүдлийн соёл иргэншилт үндэсний хөгжлийн нэгдсэн эрх зүйн зохицуулалт, сонгодог эко хөгжлийн бодлогыг удирдан хөгжүүлэх;
 - Үндэсний хөгжлийн нийгэм соёлын эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
 - Үндэсний хөгжлийн нийгэм улс төрийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
 - Үндэсний хөгжлийн нийгэм эдийн засгийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
2. Бүсчилэн хөгжүүлэх нэгдмэл эрх зүйн зохицуулалт, сонгодог Геополитикийн бодлогыг удирдан хөгжүүлэх;
 - Бүсчилсэн хөгжлийн нийгэм соёлын эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
 - Бүсчилсэн хөгжлийн нийгэм улс төрийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
 - Бүсчилсэн хөгжлийн нийгэм эдийн засгийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
3. Үндэсний соёлт нүүдэлчин Монгол аймгийн хөгжлийн нэгдмэл эрх зүйн зохицуулалт, сонгодог Монгол хөгжлийн бодлогыг удирдан хөгжүүлэх;
 - Нүүдэлчин Монгол Аймгийн хөгжлийн нийгэм соёлын эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
 - Нүүдэлчин Монгол Аймгийн хөгжлийн нийгэм улс төрийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;
 - Нүүдэлчин Монгол Аймгийн хөгжлийн нийгэм эдийн засгийн эрх зүйн зохицуулалтыг ёсчлон журамлаж баталгаажуулан удирдан хөгжүүлэх;



Иргэний хөдөлгөөний намын Хөвсгөл аймгийн намын хорооны
Тэргүүлэгчдийн 2024 оны 06 сарын 17-ний өдрийн
090 тоот тогтоолоор батлав

ҮР ДҮН: “Нэгдмэл Эрх Зүйт Монгол Хөгжлийн төлөө” мөрийн хөтөлбөрийн
хүрээнд

1. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн Монгол Улс;
2. Дэлхийн Нийгэм Улс Төрийн Ирээдүйн Хараа Монгол Улс;
3. Дэлхийн Санхүү Эдийн Засгийн Ирээдүйн Шийдэл Монгол Улс;

